

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	6
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	10
4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13
4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн Тайлангийн Аудит
ТХН	Төсөл Хэрэгжүүлэгч Нэгж
ТӨҮГ	Төрийн Өмчит Үйлдвэрийн Газар
АХБ	Азийн Хөгжлийн Банк



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

“БАРУУН БҮСИЙН БОСОО ТЭНХЛЭГИЙН
АВТО ЗАМ ХӨГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ-1
(МОН-2847)”-ИЙН ЗОХИЦУУЛАГЧ
Б.БАЯН-АМГАЛАН ТАНАА

2020.04.14 № 06/1132
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл-1 (МОН-2847)”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл-1 (МОН-2847)”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл-1 (МОН-2847)”-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл-1 (МОН-2847)” нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай, нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл-1 (МОН-2847)”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төслийн зохицуулагч Б.Баян-Амгалан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгадаг боловч аудитаар зөвлөмж өгөх асуудал илрээгүй болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл-1 (МОН-2847)”-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл-1 (МОН-2847)”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 3 дугаар сарын 3-наас 2020 оны 4 дүгээр сарын 3-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Грант Торнтон аудит” ХХК-ийн аудитор Б.Алтансарнай, туслах аудитор Ц.Баттуяа нар Үндэсний аудитын газрын захиалгаар хариуцаж хэрэгжүүлэв.

“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл-1 (МОН-2847)”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Грант Торнтон аудит” ХХК-д 2020 оны 3 дугаар сарын 02-ны өдөр ирүүлсэн бол Үндэсний аудитын газарт тайланг ирүүлээгүй байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл-1 (МОН-2847)”-ийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь өөрийн орон нутаг дэвсгэрээр олон улсын транзит тээврийг нэвтрүүлэх боломжийг бүрдүүлсэн, манай улсын баруун бүс нутгийн нийгэм, эдийн засаг, дотоодын авто тээврийг эрчимтэй хөгжүүлэх, улмаар хөрш орнуудын дамжин өнгөрөх ачаа, зорчигч тээвэрлэлтийг нэмэгдүүлж, дотоодын худалдаа, зах зээлийг хөгжүүлэн олон улс, бүсийн ач холбогдол бүхий нийгэм, эдийн засгийн үр ашигтай, Азийн замын стандартад нийцсэн, техникийн аюулгүй байдлыг хангасан Ярант-Ховд-Өлгий-Улаанбайшинт чиглэлийн 743.1 км авто зам барих юм.

2019 оны төслийн хэрэгжилтийн хувьд “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замын хөгжүүлэх төсөл (МОН-2847)”-ийн хүрээнд АХБ-ны зээл, буцалтгүй тусламжаар Баруун бүсийн босоо тэнхлэгээс Мөст сум хүртэлх 20.3 км хатуу хучилттай авто зам барих ажлыг гүйцэтгэсэн ба 2019 оны 10 дугаар сарын 31-нээр төслийг хаасан байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл-1 (МОН-2847)”-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Төсөл нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Microsoft Excel” программ хангамж ашигладаг байна.

Төслийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл-1 (МОН-2847)”-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 9 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 5,233,935.6 мянган төгрөгөөс тооцон 52,339.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг өөрчлөөгүй болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл-1 (МОН-2847)”-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 5,261,359.5 мянган төгрөгөөр буюу 152 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт Б	/мянган төгрөг/		
	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	Өөрчлөлт 3=2-1
Мөнгөн хөрөнгө	276.8	276.0	(0.8)
Авлага	-	27,425.4	27,425.4
Урьдчилж төлсөн зардал	1,500,000.0	-	(1,500,000.0)
Нөөцийн бараа	1,966,723.7	8,700,658.7	6,733,935.0
Үндсэн хөрөнгө	-	-	-
Нийт хөрөнгө	3,467,000.6	8,728,360.1	5,261,359.5
Өр төлбөр	-	27,425.4	27,425.4
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,467,000.6	8,700,934.7	5,233,934.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,467,000.6	8,728,360.1	5,261,359.5

“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл-1 (МОН-2847)” нь 2019 оны 10 дугаар сарын 31-нээр хаагдаж мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг 2020 оны 3 дугаар сарын 6-ны өдөр Сангийн яамны 100900080005 тоот дансанд төвлөрүүлсэн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс урьдчилж төлсөн зардал, нөөцийн бараа, засгийн газрын оролцоо дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Урьдчилж төлсөн зардал дансанд 2018 онд "Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замаас Мөст сум хүртэлх 20.3 км хатуу хучилттай авто замын барилгын ажил"-ын гэрээний урьдчилгаа 1,500,000.0 мянган төгрөгийн төлбөрийг бүртгэж 2019 онд замын ажлын гүйцэтгэлийг хүлээн авснаар нөөцийн бараа дансанд капиталжуулан бүртгэсэн байна.

Нөөцийн бараа дансанд 2018 онд гүйцэтгэгчид урьдчилж төлсөн 1,500,000.0 мянган төгрөгийн төлбөр болон 2019 оны 3,284,045.9 мянган төгрөгийн АХБ-ны зээлийн санхүүжилт, 1,949,880.6 мянган төгрөгийн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн, Зам, тээврийн хөгжлийн яаманд хүлээлгэн өгөх авто замыг бүртгэсэн байна.

Үндсэн хөрөнгийн дансанд 9,428.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, элэгдлээрээ өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг бүртгэсэн ба Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 3007 тоот тушаалаар акталж данснаас хассан байна.

Авлага ба өр төлбөрийн дансанд АХБ-ны зээлийн санхүүжилтээр төлөх төслийн усны чанарт хяналт тавьж, мониторинг хийсэн бие даасан зөвлөхийн үлдэгдэл төлбөр 27,425.4 мянган төгрөгийг бүртгэсэн ба 2020 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр АХБ-наас гүйцэтгэгч рүү шууд шилжүүлэг хийснээр авлага, өр төлбөрийн дансдыг хаасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 5,261,359.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд замын ажлын гүйцэтгэлийг АХБ-ны зээлийн орлого 3,284,045.9 мянган төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтын 1,949,880.6 мянган төгрөгөөр санхүүжүүлсэнтэй холбоотой.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл-1 (МОН-2847)”-ийг хэрэгжүүлэхэд зориулан 5,270,416.5 мянган төгрөгийн төсөв батлагджээ.

Төслийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 276.8 мянган төгрөг байсан бол гүйцэтгэлээр 3,284,045.9 мянган төгрөгийн санхүүжилтийг АХБ-наас, 1,949,880.6 мянган төгрөгийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаас олгож, 9.2 мянган төгрөгийн харилцах дансны хүүгийн орлого бүрдүүлж, 10.0 мянган төгрөгийг банкны шимтгэлд, 5,233,926.5 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагаанд зарцуулж, 276.0 мянган төгрөгийн төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 5,233,926.5 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 7 чиглэлээр 9 эрсдэл тогтоож тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлж, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тайлагналын алдаатай холбоотой 3,311,471.3 мянган төгрөгийн дараах асуудлуудыг залруулан санхүүгийн тайланд тусгаж, “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл-1 (МОН-2847)”-ийн удирдлагаар зөвшөөрүүлэн баталгаажуулав. Үүнд:

1. Төслийн усны чанарт хяналт тавьж, мониторинг хийсэн бие даасан зөвлөхийн үлдэгдэл төлбөр 27,425.4 мянган төгрөгийг АХБ-ны зээлийн авлагаар бүртгэх байсныг урьдчилж төлсөн зардал дансанд бүртгэсэн нь санхүүгийн тайлангийн Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

2. Мөнгөн гүйлгээний тайланд АХБ-наас гүйцэтгэгчид шууд шилжүүлсэн 3,284,045.9 мянган төгрөгийг гадаад эх үүсвэрээс санхүүжих орлого, гадаад эх үүсвэрээс санхүүжих хөрөнгийн зардалд бүртгэсэн нь санхүүгийн тайлангийн Толилуулга ба тодруулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл-1 (МОН-2847)” нь 2019 оны 10 дугаар сарын 31-нээр хаагдаж байгаатай холбогдуулан дараах 2 асуудлуудыг анхаарал татахуйц гэж үзлээ. Үүнд:

- Нөөцийн бараа дансанд бүртгэсэн авто замыг Зам, тээврийн хөгжлийн яаманд хүлээлгэн өгөх үйл ажиллагаа;
- Төслийн хаалтын өдрөөс хойш санхүүгийн хаалтын хугацаа хооронд гарсан ажил гүйлгээ байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

“Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл-1 (МОН-2847)” нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус төсөл нь 2019 онд Шилэн дансны тухай хуулийн дагуу төсөв гүйцэтгэлийн 9 мэдээлэл, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 5 мэдээлэл, бусад 6 мэдээлэл,

нийт 20 мэдээлэл байршуулахаас 11 мэдээллийг зарим саруудад хугацаа хоцорч байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл-1 (МОН-2847)”-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Төслийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл-1 (МОН-2847)”-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

2019 оны 10 дугаар сарын 31-нээр “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл-1 (МОН-2847)”-ийн үйл ажиллагаа хаагдаж байгаатай холбоотойгоор аудит хийх явцад цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй асуудал илрээгүй тул Менежментийн захидалд зөвлөмж тусгаагүй болно.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,467,000,637.95	8,728,360,180.97
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	276,872.30	276,030.85
312	Банканд байгаа бэлэн мөнгө	276,872.30	276,030.85
3121	Төгрөг	-	-
31211	Төрийн сангийн харилцах	-	-
3122	Гадаад валют	276,872.30	276,030.85
31223	Арилжааны банк дахь харилцах	276,872.30	276,030.85
33	АВЛАГА	-	27,425,406.16
336	Зээлийн авлага	-	27,425,406.16
3362	Гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн зээлийн авлага	-	27,425,406.16
33621	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон	-	27,425,406.16
34	УРЬДЧИЛГАА	1,500,000,000.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	1,500,000,000.00	-
36	НӨӨЦИЙН БАРАА	1,966,723,765.65	8,700,658,743.96
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	1,966,723,765.65	8,700,658,743.96
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	-
392	Биет хөрөнгө	-	-
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	9,428,080.00	-
39206	Хуримтлагдсан элэгдэл	(9,428,080.00)	-
393	Биет бус хөрөнгө	-	-
39301	Программ хангамж	3,394,000.00	-
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,394,000.00)	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,467,000,637.95	8,728,360,180.97
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	27,425,406.16
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	27,425,406.16
413	Өглөг	-	27,425,406.16
4136	Бусад өглөг	-	27,425,406.16
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	27,425,406.16
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,467,000,637.95	8,700,934,774.81
51	Засгийн газрын хувь оролцоо	3,467,000,637.95	8,700,934,774.81
512	Хуримтлагдсан үр дүн	3,467,000,637.95	8,700,934,774.81
51210	Өмнөх үеийн үр дүн	1,970,753,090.65	3,467,000,637.95
51220	Тайлант үеийн үр дүн	1,496,247,547.30	5,233,934,136.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,467,000,637.95	8,728,360,180.97

4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,727,235,695.45	5,233,935,645.16
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	227,235,695.45	3,284,055,045.46
120	Нийтлэг татварын бус орлого	18,771.30	9,158.55
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	18,771.30	9,158.55
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,771.30	9,158.55
124	Зээлийн орлого	227,216,924.15	3,284,045,886.91
141001	Гадаад санхүүгийн зээлийн эх үүсвэр	227,216,924.15	3,284,045,886.91
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,500,000,000.00	1,949,880,599.70
1330	Төсвийн захирагчдаас	1,500,000,000.00	1,949,880,599.70
133004	Төсвийн ерөнхийлөн захирагчаас олгосон санхүүжилт	1,500,000,000.00	1,949,880,599.70
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	230,988,148.15	10,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,771,224.00	10,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,771,224.00	10,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,771,224.00	10,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	10,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,771,224.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	227,216,924.15	-
2260	Гадаад эх үүсвэрээр	227,216,924.15	-
226001	Гадаад эх үүсвэрээр	227,216,924.15	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,496,247,547.30	5,233,925,645.16
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	8,491.70
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	-	8,491.70
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	-
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	20,442,973.69	8,491.70
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,496,247,547.30	5,233,934,136.86

4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,727,235,695.45	9,158.55
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,727,235,695.45	9,158.55
120	Нийтлэг татварын бус орлого	1,727,235,695.45	9,158.55
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,727,235,695.45	9,158.55
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,500,000,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,771.30	9,158.55
1200044	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	227,216,924.15	-
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,500,000,000.00	10,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,500,000,000.00	10,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	10,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	10,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	10,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,500,000,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,500,000,000.00	-
213304	Хөрөнгийн	1,500,000,000.00	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	227,216,924.15	(841.45)
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	227,216,924.15	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	227,216,924.15	-
2260	Гадаад эх үүсвэрээр	227,216,924.15	-
226001	Гадаад эх үүсвэрээр	227,216,924.15	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(227,216,924.15)	-
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(841.45)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	18,771.30	(841.45)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	258,101.00	276,872.30
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	276,872.30	276,030.85

4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	1,970,753,090.65	1,970,753,090.65
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	1,970,753,090.65	1,970,753,090.65
Тайлант үеийн үр дүн	-	1,496,247,547.30	1,496,247,547.30
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	3,467,000,637.95	3,467,000,637.95
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	3,467,000,637.95	3,467,000,637.95
Тайлант үеийн үр дүн	-	5,233,934,136.86	5,233,934,136.86
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	8,700,934,774.81	3,467,000,637.95

4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		276,872.30		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,270,416,499.70	5,233,926,486.61	36,490,013.09	99.3
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	5,270,416,499.70	5,233,926,486.61	36,490,013.09	99.3
Дотоод эх үүсвэрээр	1,949,880,599.70	1,949,880,599.70	-	100.0
Барилга байгууламж	1,949,880,599.70	1,949,880,599.70	-	100.0
Гадаад эх үүсвэрээр	3,320,535,900.00	3,284,045,886.91	36,490,013.09	98.9
Гадаад эх үүсвэрээр	3,320,535,900.00	3,284,045,886.91	36,490,013.09	98.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	5,270,416,499.70	5,233,926,486.61	36,490,013.09	98.9
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,949,880,599.70	1,949,880,599.70	-	100.0
Улсын төсвөөс санхүүжих	1,949,880,599.70	1,949,880,599.70	-	100.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,320,535,900.00	3,284,045,886.91	36,490,013.09	98.9
Гадаад эх үүсвэрээс санхүүжих	3,320,535,900.00	3,284,045,886.91	36,490,013.09	98.9
Төсвийн тохируулга		(841.45)		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		276,030.85		

